

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН БАТАЛСАН 29/02 ТООТ УДИРДАМЖИЙН ДАГУУ ХАРХОРИН СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, БАРУУНБАЯН-УЛААН, ХУЖИРТ СУМДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭМИЙН ГҮЙЦЭТГЭЛД ДОТООД АУДИТЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭЛЭЭ.

1. Нийтлэг үндэслэл

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу орон нутгийн төсвийн төлөвлөлтийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалтыг үндэслэн дотоод аудит хийж дүгнэлт өгөх, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

2. Дотоод аудитын зорилго

Эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн төлөвлөлт, захиалгын үндэслэл, худалдан авалт, зарцуулалт, эмийн нөөц бүрдүүлэлт, эмчилгээ, оношлогооны стандарт, удирдамж мөрдөлт, эмийн зардлыг нягтлан бодох бүртгэл, тайлан балансад тусгаж байгаа байдал, өр авлагын байдлыг үнэлэн, дотоод аудит хийж, эрүүл мэндийн байгууллагуудын хэмжээнд эрсдэлтэй, дотоод хяналт сул хэрэгжиж буй асуудлыг тодорхойлж, холбогдох заавар зөвлөмжөөр хангах.

3. Дотоод аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төв, Хужирт сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны эмийн үйл ажиллагааг хамруулах бөгөөд сонгогдсон эрүүл мэндийн төвүүдийн зөвхөн эмийн үйл ажиллагаанд чиглүүлэхийг зорьсон, мөн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цаг хугацаанд аудитыг багтааж, үр дүнг тайлагнах шаардлагатай тул дурдсан байгууллагуудын засаглалын бүтэц, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явц, санхүүгийн үйл ажиллагааг бүхэлд нь авч үзэхгүй боловч эдгээрийн зөвхөн эмийн үйл ажиллагаатай холбогдох хэсгийг хамруулна. Мөн төрийн аудитаас “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд аймгийн хэмжээнд аудит хийгдэж байгаа тул бодлогын хэрэгжилтийг хамруулахгүй.

4. Дотоод аудитын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд байгууллагын аудиторууд, аймгийн Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга, хүүхдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, эмийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, ахлах нягтлан бодогч нартай хамтран хийж гүйцэтгэсэн.

ИЛЭРСЭН АСУУДАЛ	ӨГСӨН ЗӨВЛӨМЖ
<p>1. Эмийн гаж нөлөөний бүртгэл хөтөлж байгаа ч албан ёсоор бүртгэлжүүлсэн баримтгүй, гаж нөлөөг удирдах дээд байгууллагад мэдээлдэггүй, сүүлийн 3 жилийн антибиотикийн хэрэглээний судалгаа хийгдээгүй, эмийн суурь судалгаа иж бүрэн биш</p>	<p>1. Эмнэлзүйн эм зүйг хөгжүүлэх чиглэлээр дорвитой ажлууд зохион байгуулах, эмийн үл нийцэл, гаж нөлөөний талаар бүртгэлийн сан гаргах, сургалт зохион байгуулах.</p> <p>2. Антибиотикийн хэрэглээний судалгааг сүүлийн 3 жилээр гарган, жил бүр баяжилтыг хийж байх</p> <p>3. Эмийн суурь судалгааг хийхдээ зонхилон тохиолдох өвчлөл, антибиотикийн хэрэглээний судалгаа, эмийн гаж нөлөөний судалгаа, стандарт, удирдамжийн хэрэгжилт зэрэг асуудлуудтай уялдуулан хийж хэвших, сүүлийн 3-аас 5 жилийн эмийн суурь судалгаатай болох</p> <p>4. Эмтэй холбоотой алдаа, тохиолдлыг бүртгэх, түүний мөрөөр тодорхой ажлууд зохион байгуулах</p> <p>5. Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдээс оношилгоо эмчилгээний стандарт, удирдамж заавруудын мөрдөлтийг сайжруулах хяналтыг тогтмолжуулах</p>
<p>2. Эмийн захиалга суурь судалгаатай уялддаггүй</p>	<p>6. Эрүүл мэндийн газраас сумдын эрүүл мэндийн төвүүдийн эмийн захилага авах тухай журам боловсруулж мөрдүүлэх. Үүнд ямар төрлийн суурь судалгааг яаж хийх, ямар төрлийн тооцоолол хийсэн байх тухай маягт, зааварчилгааг багтаах.</p> <p>7. Сумдын эрүүл мэндийн төвүүд эмийн захиалга өгөхдөө зөвхөн урд оны эмийн зарцуулалтаар бус холбогдох суурь судалгаануудтай уялдуулан дүн шинжилгээ, тооцоолол хийж хэвших.</p> <p>8. Нэгдсэн эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн төвүүд хуульд заасан судалгаануудыг хийж, мэдээллийн сан бүрдүүлж, тогтоосон хугацаанд байгууллагын удирдлагад тайлагнаж хэвших, энэ үйл ажиллагаанд Эрүүл мэндийн газраас хяналт тавьж ажиллах.</p>
<p>3. Техникийн тодорхойлолтыг ор нэр төдий хийсэн.</p>	<p>9. Техникийн тодорхойлолтыг суурь судалгаа, статистик мэдээлэл, орон нутгийн тэргүүлэх өвчлөл, эмийн хэрэглээний судалгаа, эмийн шинэчлэл, өөрчлөлт, үр дүн зэргийг үндэслэн эмийн нэршил, найрлага, тун хэмжээ, тоо ширхэг, чанар, стандарт, сав баглаа боодол, гарал үүсэл, жишигдэхүйц эм дурдах гэх мэт үзүүлэлтүүдийг нарийн тооцоолж багц тус бүрээр боловсруулан үнэлгээний хороонд өгч байх.</p> <p>10. Үнэлгээний хороо захиалагч талаас ирүүлсэн техникийн тодорхойлолтыг хянан үзэж эцсийн хувилбараар боловсруулан баталж байх.</p> <p>11. ТБОНӨХБАҮХАТухай хуульд эмийн техникийн тодорхойлолтыг илүү нарийн үзүүлэлтээр боловсруулах боломжийг нээж өгөх тухай заалт оруулах санал хүргүүлэх.</p>

<p>4. Үнэлгээний хорооны дэргэд үнэлгээ хийх мэргэжлийн өөр тусдаа баг ажилладаггүй.</p>	<p>12. ТБОНӨХБАҮХАТХуульд үнэлгээний хорооны дэргэд үнэлгээ хийхэд дэмжлэг, зөвлөгөө өгөх чиглэл бүхий мэргэжлийн баг ажиллуулах, үнэлгээг нарийн хийх боломжийг бүрдүүлэх үүднээс үнэлгээ хийх хугацааг уртасгах зэрэг боломжийг нээсэн заалтуудыг оруулах талаар санал өгөх.</p> <p>13. Үнэлгээний хороо байгуулахдаа эмнэлгийн мэргэжлийн гишүүдийг 5-с доошгүй байхаар тооцож гишүүдийг бүрдүүлэх.</p>
<p>5. Нийлүүлэлт хоцорсон тохиолдолд хариуцлага тооцдоггүй.</p>	<p>14. Гэрээ байгуулсан аж ахуй нэгжийн эмээ хуваарийн дагуу нийлүүлж байгаа эсэхийг албан ёсоор бүртгэлжүүлэх.</p> <p>15. Нийлүүлэлт хоцорсон тохиолдолд ямар шалтгаанаар ямар эм эмнэлгийн хэрэгсэл хоцорсоныг тодорхой хөтлөн баримтжуулж байх</p> <p>16. Аймгийн ЭМГазар эм бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг улирал бүр дүгнэн, үр дүнг тооцон ажиллах</p> <p>17. Ерөнхий гэрээнд тусгагдсан эмүүдийг зохих журмын дагуу гэрээ байгуулан худалдан авалтыг хийж байх.</p>
<p>6. Шаардлага хангаагүй эмийг буцаасан тухай баримт байхгүй.</p>	<p>18. Эрүүл мэндийн газар нь нийлүүлэгч байгууллагуудаас эм хүлээн авахдаа ажлын хэсэг томилон техникийн тодорхойлолттой нэг бүрчлэн тулган шалгаж, холбогдох хяналтыг хийж энэ тухай баримт, акт, тэмдэглэл үйлдэж хэвших.</p> <p>19. Шаардлага хангаагүй болон хугацаа дуусах дөхсөн эм нийлүүлэгдсэн тохиолдлыг бүртгэлжүүлж мэдээллийн сан үүсгэх, зөрчлийг удаа дараа давтан гаргасан бэлтгэн нийлүүлэгчийг дараагийн тендер үнэлэхэд харгалзан үздэг болох.</p> <p>20. Сумдын ЭМТөвүүд хугацаа дуусах дөхсөн болон шаардлага хангаагүй эмийг буцаахдаа орлогын падаанаас хасч бус буцаалтын акт үйлдэн баталгаажуулж байх.</p> <p>21. Аймгийн ЭМГазар ТӨОЗ 19.1(б)-д нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хүчинтэй байх хугацааг 1-3 жил байхаар тусгасан заалтыг эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тухай гэрээнд тусган өгөх</p> <p>22. Сумдын эрүүл мэндийн төвүүд эм нийлүүлэх гэрээний хэрэгжилтийг шилэн данс болон олон нийтэд танилцуулан ажиллах</p>
<p>7.Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн оношилгоо эмчилгээний удирдамж, зааврын мөрдөлт хангалтгүй.</p>	<p>23. Чанарын алба, багийг томилон, ажиллах журам, график төлөвлөгөөг гарган үйл ажиллагааг тогтмолжуулах</p> <p>24. Дотоод хяналт хийх бусад багуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх, багуудын уялдаа холбоог сайжруулах, үр дүнг тооцох</p>

	<p>25. Байгууллагын удирдлага, Эмчилгээ эрхэлсэн орлогчоос өвчний түүх бичилт, оношилгоо эмчилгээний мөрдөлт, эмийн зарцуулалтанд тухай бүр хяналт хийх, чанарын багтай хамтран ажиллаж антибиотикийн болон эмийн зохистой хэрэглээнд дүгнэлт хийж ажиллах, эмч мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулах</p> <p>26. Өвчтөнд хийсэн эм тарианы бүртгэл хөтлөлтийг дүрэм журам, стандартын дагуу бүрэн гүйцэд хөтлөх</p> <p>27. Эмчилгээ хийгдэж эхлэхэд, явц дунд, дуусахад өвчтөнд эмчилгээг танилцуулж гарын үсэг зуруулдаг, эмчилгээг бүрэн хийсэн эсэхийг өвчтөнөөр хянуулж, баталгаажуулах тухай эрх зүйн зохицуулалттай болохоор санал дэвшүүлэх, өөрийн байгууллагаас журам боловсруулан ажиллах</p>
<p>8. Эм эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, нөөц бүрдүүлэлт, зарцуулалт, бүртгэл хөтлөлт хангалтгүй, Хужирт сумын Эрүүл мэндийн төв эмийн он дамжсан өр үүссэн</p>	<p>28. Эмнэлгийн эм зүйч, эм баригч нар /Хархорин сумын нэгдсэн эмнэлэг E-Health программ дах/ эмийн үлдэгдлийг бодит эмийн үлдэгдэлтэй харьцуулж өдөр бүр тулгалт хийдэг байх</p> <p>29. Сар бүр эмийн тооллогыг хийж, эмийн илүүдэл дутагдлыг гаргахгүй ажиллах</p> <p>30. Эмийн орлого зарлага, хүчинтэй хугацаа, хадгалалтад хяналт тавих, зарцуулалтыг бүрэн хөтлүүлэх</p> <p>31. Эмийн нөөцийг 1-ээс 3 сарын хугацаанд ашиглахаар тооцон бүрдүүлж ажиллах</p> <p>32. Эмч нарын тавьсан оношийн дагуу эмчилгээ зөв бичигдсэн эсэх, хөтлөгдөж буй анхан шатны маягт материалууд бүрэн гүйцэд эсэхэд чанарын багаас тогтмол хяналт тавих, үр дүнг тооцон ажиллах</p> <p>33. Эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилтийг нэхэмжилсэн дүнгээр бүрэн гүйцэд авч чадаж байгаа эсэхийг хянан, хасагдсан тохиолдолд юунаас шалтгаалсныг тодруулж холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон ажиллах</p> <p>34. Эмийн төсвийг зөв төлөвлөн, зохих дүрэм журмын хүрээнд захиран зарцуулах талаар санал санаачлагатай ажиллах</p> <p>35. Эмийн төсөв хүрэлцэхгүй байгаад дүн шинжилгээ хийж, холбогдох материалуудыг бүрдүүлэн удирдах дээд байгууллагад уламжлан шийдвэрлүүлж байх</p>